



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 18 өдөр

Дугаар А/269

Булган сум

Гүйцэтгэгчид гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын XIV Хуралдааны 2023 оны XIV/01 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээнд тусгагдсан бохир соруулах тоноглогдсон автомашин (Тэшиг сум) нийлүүлэх ажлын гүйцэтгэгчээр шалгарсан "Арби элеваторс" ХХК-тай 56,160,000 (тавин зургаан сая нэг зуун жаран мянга) төгрөгөөр гэрээ байгуулах эрхийг Байгаль орчин, аялал жуулчлалын газар (А.Гантөмөр)-т олгосугай

2. "Арби элеваторс" ХХК-ийн ажлын гүйцэтгэлд холбогдох хууль, тогтоомж, гэрээний дагуу хяналт тавьж, хүлээн авах ажлыг зохион байгуулахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газар (А.Гантөмөр)-т даалгасугай.

3. Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль, журам, стандартын дагуу гүйцэтгэж, хүлээлгэн өгөхийг "Арби элеваторс" ХХК-ийн захирал (Э.Уртнасан)-д үүрэг болгосугай.

4. Тус ажлын санхүүжилтийг холбогдох хууль, тогтоомж, гэрээний дагуу Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээний сангаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч (П.Булган)-д зөвшөөрсүгэй.

5. Тус тоног төхөөрөмжийг нягтлан бодох бүртгэлийн хууль журмын хүрээнд бүртгэж, ашиглалт, хадгалалт, хамгаалалтад Орон нутгийн өмчийн тухай хуулийн дагуу хяналт тавьж ажиллахыг Тэшиг сумын Засаг дарга (Ж.Гансүх)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  БАРИУН-ЭРДЭНЭ



Булган Аймаг 2023 өдөр бүр Дор/2023/Захирамж

6323010254